



Завхан аймгийн Монгол Ардын Хувьсгалт Намын  
Түмтийн 2020 оны 06 дугаар сарын 15-ны  
өдрийн хуралдааны тогтоолын хавсралт

## ЗАВХАН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### ИРГЭДЭЭР ОВОГЛОСОН, ИРГЭДИЙН ТӨЛӨӨ “ЭРҮҮЛ ЗАВХАН” ХӨТӨЛБӨР

#### ЗОРИЛГО


Монгол Ардын Хувьсгалт Нам нь аймаг орон нутгийн иргэдийнхээ ашиг, сонирхлыг удирдлага болгож, ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологийн чиг баримжаатай улс төр нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Монгол хүн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг дээдлэж Өрх бүрт орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэн жил бүр олон мянган өрхийг орон сууцаар хангах хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх
- Залуучуудаа төр засгийн зардлаар дээд боловсрол олгож, нарийн мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх
- Иргэн бүрийн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний зардлыг төрийн өмчийн эмнэлгээр үйлчлүүлэхэд төр засгаас бүрэн хариуцаж иргэд эрүүл мэндээ хамгаалуулах эрхээ бүрэн эдлэх,
- Иргэдээ ажлын байраар хангах, орлогын найдвартай эх үүсвэртэй болгох,
- Иргэдийн авах цалин амьдралд нь хүрэлцэхүйц байх, ингэснээр хөдөлмөрийн хөлсөөрөө сайхан амьдрах боломжийг бүрдүүлэх,
- Ядууралд өртсөн иргэдээ “Хүрэлцэхүйц орлого”-той болгох, ядуурлыг бүр мөсөн арилгах,
- Төр засгийн бүх шатны байгууллагуудыг авлигаас бүрэн цэвэрлэх болно.

Орон нутгийн төр засгийн байгууллага, албан тушаалтнууд хариуцлага хүлээдэггүй өнөөгийн гаж тогтолцоог халж Монгол хүнийг хамгаалдаг иргэндээ ээлтэй нутгийн захиргааны шинэ тогтолцоонд шилжинэ.

МАХН нь эх оронч үзэлтэй мянга мянган шударга иргэдийн ирүүлсэн экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн хөгжлийн өнөөгийн дүр төрхийг дүгнэсэн, улс эх орныхоо хөгжлийг хурдасгах өргөн хүрээтэй шийдвэртэй алхмуудыг санал болгож байна.

Хөтөлбөрийн хүрээнд МОНГОЛ СОЁЛ ИРГЭНШИЛ дэд хэсэгт экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн асуудлаас бүрдсэн хоорондоо харилцан хамааралтай хүн төвтэй хөгжлийн бодлогыг бий болгоно.



## **НЭГ. ИРГЭН ТАНЫ АМЬДРАЛД:**

Иргэн та нас, хүйс, шашин шүтлэг, намын харъяалал, угсаа гарал, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мөн мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй Эрүүл орчинд амьдран сурч боловсрох эрхтэй. Үүнд:

- Төрийн болон хувийн хэвшлийн салбарт нас, хүйс, зүс царайгаар ялгаварлан гадуурхахыг таслан зогсоох
- 0-2 насны хүүхдээ асарч байгаа эцэг эхчүүдэд тухайн орон нутгийн төсвөөс амьдрах хэмжээнд хүрэхүйц “баталгаатай орлого”-ыг олгох,
- Жирэмсэн эмэгтэйчүүд 3-5 насны хүүхэдтэй ажилчин, ажилтныг ажиллуулж буй аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжих,
- “Монгол хүн-Оюунлаг иргэд” харилцааг төлөвшүүлэх зорилгоор хүүхэд бүр амьдралын түвшнээс үл хамааран цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн болон Их дээд сургуульд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх,
- 0-5 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрт дэмжлэгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,
- Иргэн бүр дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэд тоног төхөөрөмж, технологи бүхий төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний зардлыг төр засаг бүрэн хариуцдаг тогтолцоог бүрдүүлж эхлүүлэх,
- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих зорилгоор иргэд биеийн тамирыг хүн бүрийн амьдралын эрүүл дадал болгох нөхцөл бололцоог нээхийн зэрэгцээ “ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ”, “ЗӨВ ХҮНС” хөтөлбөр хэрэгжүүлэх эдгээр болно.

## **ХОЁР. ӨРХ, ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛД:**

Монгол Улсын тулгуур баялаг нь “Монгол өрх” мөн тул аймгийн төвд амьдарч буй өрх гэр, залуу гэр бүл, иргэдийг тохилог орон сууцанд амьдрах бодлогыг боловсруулан өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана. Үүнд:

- Аймгийн төв, сумдад хувийн орон сууц барих бодлогыг дэмжин ажиллах.
- Бичил болон өрхийн бизнесийг дэмжих талаар нийслэл, аймгийн төвүүдэд зөвлөх үйлчилгээг үзүүлэх төвүүд байгуулах, нас насны онцлогт харгалзсан тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих санхүү, зээлийн төвүүдийг дэмжих зэрэг зорилтот бичил банк, санхүүгийн байгууллага байгуулж, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгосноор айл өрх, аж ахуйн нэгжийн орлого, бизнесийн боломжийг нэмэгдүүлж, ажлын байрыг шинээр бий болгоно.

## **ГУРАВ. АЙМАГ, СУМЫН ХҮРЭЭНД:**

- Сумдад залуучуудад зориулсан гарааны бизнесийг дэмжих “Старт апп” хөтөлбөрийг хэрэгжүүлж, бизнес эрхлэгч залуучуудад зориулсан “Дундын оффис” аймгийн төвд байгуулах,
- Эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнесийг дэмжих зорилготой “Эмэгтэйчүүдийн хөгжил” банкны салбар байгуулах ажил эхлүүлнэ



- Амйгийн хэмжээнд жил бүр 200 гарааны бизнесийг дэмжиж бойжуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд зориулсан уян хатан ажиллах ажлын байр олноор бий болгох,
- Ахмадуудыг төр засгийн байгууллагад сайн дурын зөвлөхөөр авч ажилуулж, ахмад мэргэжилтнүүдийг зохих урамшуулалтайгаар ажиллуулсан ААН-үүдийг татварын тогтолцоогоор урамшуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сувилал, сэргээн засах төвийг байгуулах ажлыг эхлүүлэх.
- Аймаг, орон нутгийн ногоон орчин, гол ус бүхий орчинд иргэдийн оролцоотой байгальд ээлтэй эко аймаг, сум хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Иргэд амьдрах таатай эрүүл цэвэр, ногоон технологи бүхий хаягдалгүй орчинг иргэдийн оролцоотойгоор бүрдүүлэх,
- Аймаг, сумын төвүүдэд Төр хувийн хэвшлийн оролцоотой хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлсэн цэнгэлдэх хүрээлэн, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах эрхийг аж ахуйн нэгжүүдэд чөлөөтэй олгох,
- Аймаг, сумын төвүүдэд хөдөө аж ахуйн бүтээгдхүүн, малын гаралтай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх эрх зүйн өөрчлөлтийг хийх,
- Хүнсний аюулгүй байдлыг ханган, малын гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг экспортлон малчдын орлогыг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор малыг эрүүлжүүлэх аяныг өрнүүлэх,
- Зах зээлийн мэдрэмжтэй, хөрвөх чадвар сайтай, зохистой сүргийн, малжуулах зээлийг төр-арилжааны банкны хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлж, зээлийн дарамтнаас малчдыг чөлөөлөх боломжийг бүрдүүлэх,
- Сумдад “Цагаан алт” болох ноосыг боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих,
- Орон нутгийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүй, удирдлагын туслалцаа үзүүлэх, боловсон хүчний асуудал, бүс нутгийн МСҮТ боловсон хүчний сургалт дадлагажилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Бүх сумдын Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэн хүүхдэд ээлтэй ногоон орчин бүрдүүлэх бодлогыг дэмжиж хэрэгжүүлэх,
- “Эрүүл зөв амьдрал”, “Зөв хүнс” хөтөлбөрийг цэцэрлэг, сургууль, олон нийтийн үйлчилгээний газруудад нэн тэргүүнд хэрэгжүүлэх
- Багш нарыг орон сууцжуулах, хөдөө орон нутагт багшлах боловсон хүчнийг дэмжих, сургалтад хамруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор аймаг, сумын засаг даргын дэргэд “Багш” сан байгуулж ажиллуулах
- Нийтийн үйлчилгээ болон зорчих тээврийн орчин нөхцөлийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тэдэнд ээлтэй, хүртээмжтэй, саадгүй байх олон улсын стандартад нийцсэн хуулийг санаачилж хуульчилна
- Сумдын иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог сайжруулна
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулинд өөрчлөлт оруулан, орон нутгийн төсөв, санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллана
- Аймаг, сумын засаг даргыг иргэд шууд сонгодог огтолцоог бий болгоно



- Дөрвөлжин, Алдархаан, Сонгино, Ургамал, Завханмандал сумдад бэлчээрийг худаг усаар хангахад дэмжлэг үзүүлэнэ
- Шилүүстэй, Цагаанчулуут сумдын ундны усны асуудлыг шийдвэрлэнэ
- “Старт апп” хөтөлбөрийн хүрээнд Их-уул, Баянтэс сумдад Ноосны үйлдвэр байгуулна
- Баянхайрхан, Идэр, Нөмрөг сумдад Сүү, цагаан идээ боловсруулах бичил үйлдвэр байгуулна
- Эрдэнэхайрхан, Тосонцэнгэл, Тэс, Отгон сумдад аялал жуулчлалын мэдээллийн төв, жуулчны бааз байгуулна
- Бүх сумдад Мини нийтийн аж ахуйн төв байгуулна

ЗАВХАН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН  
ХУВЬСГАЛТ НАМЫН ТҮМТ

